

БАТЛАВ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

С.ЭРДЭНЭБОЛД

**“ЖАМСРАНГИЙН САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, Гучин наймдугаар зүйлийн 38.2.1 дэх заалтад “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” гэж заасан байдаг.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно” гэж заажээ.

Монгол Улсын төрийн залгамж чанар, үнэт бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дээр дурдсан хууль, эрх зүйн хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулсан байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Жамсрангийн Самбуу бол “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн нэрлэгдэж, ард түмнийхээ гүн хүндэтгэлийг хүлээсэн, өнөөг хүртэл нэр нь бүтэн байгаа төрийн зүтгэлтэн мөн. Үлгэр жишээч төрийн албан хаагч байсан Жамсрангийн Самбуугийн төрийн ажлын өвөрмөц арга барил болон манай орны эдийн засгийн тулгуур салбар болох уламжлалт мал аж ахуйг зөв зохистой эрхлэх талаарх түүний үнэ цэнтэй бүтээл, сургаалыг залуу үеийнхэнд таниулах, эзэмшүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 3 заалттай бөгөөд Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тусгана.

Гурав.Тогтоолынн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, ХХ зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, түүний алдар гавьяаг мөнхжүүлэх, эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах боломж бүрдэнэ.

Жамсрангийн Самбуугийн амьдрал, үйл ажиллагааных нь талаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж, ном, баримтат кино бүтээгдэнэ. Жамсрангийн Самбуугийн амьдралын замнал, төрийн ажлын арга туршлага болон уламжлалт мал аж ахуйн талаарх бүтээл, сургаалыг нь төрийн залуу албан хаагчид болон залуу малчдад таниулсанаар тэдэнд сайн арга туршлага, арга барилыг эзэмшүүлж, тэдний чадавхыг бэхжүүлэхэд зохих нөлөө үзүүлнэ.

Тогтоолын төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд гаргах нэмэлт хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулан хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.